


# ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ (2018 ОНЫ 4 ДҮГЭЭР САРД)

2018.05.10

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд










Аймгийн хэмжээнд 2017 оны 01 сарын байдлаар 83 эх амаржиж 84 хүүхэд мэнд төрлөө. Нялхсын эндэгдлийн 2 тохиолдол бүртгэгджээ. Цочмог халдварт өвчин 25 бүртгэгдэж өмнөх оны мөн үеийнхээс 2.3 дахин буурсан байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2018 оны 4 сарын эцэст




Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр 2018 оны эхний 4 сарын байдлаар




Хөдөлмөр, Халамжийн газарт бүртгэлтэй ажилгүй иргэд жил бүрийн 4 сарын байдлаар



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

**Төллөсөн хээлтэгч**, жил бүрийн 4 сарын байдлаар




**Гарсан төл,** жилийн бүрийн 4 сарын байдлаар




**Бойжсон төл,** жил бүрийн 4 сарын байдлаар




**Хорогдсон төл,** жил бүрийн 4 сарын байдлаар




Аймгийн дүнгээр төллөх насны хээлтэгчийн 42.2 хувь болох 638.5 мянган толгой хээлтэгч мал төллөж, 628.8 мянган төл 98.4 хувиар бойжиж байна. Төлийн хорогдол 9943 гарсан ба төрлөөр нь авч үзвэл 122 унага, 242 тугал, 51 ботго,3355 хурга, 6173 ишиг тус тус хорогджээ.

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

**Том малын зүй бусын хорогдол,**
төрлөөр, жил бүрийн 4 сарын байдлаар






**Том малын зүй бусын хорогдол,**
төрлөөр, жил бүрийн 4 сарын байдлаар




Эхний 4 сард аймгийн хэмжээнд 112.9 мянган толгой том мал зүй бусаар хорогдсон ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.6 дахин их байна. Том малын зүй бусын хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 997, үхэр 1716, тэмээ 152, хонь 27918, ямаа 82155 байна. Нийт хорогдлын 24.7 хувийг хонь, 72.7 хувийг ямаа эзэлж байна.







# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

**Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн, 2018 оны 4 сарын байдлаар, салбараар, хувиар**




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2018 оны эхний 4 дугаар сард 4 тэрбум 316.6 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.2 хувиар буурчээ. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн 35.8 хувийг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, 38.4 хувийг дулаан эрчим хүч үйлдвэрлэл, 2.8 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 14.1 хувийг нүүрс олборлолт, 9.0 хувийг усан хангамжийн салбар тус тус эзэлж байна. Нийт 5 тэрбум 351.3 төгрөгийн бүтээгдэхүүнийг борлуулсан байна.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

**Төсвийн орлогын бүтэц, мянган төгрөгөөр 2018 оны IV сард**




**Төсвийн орлого**

Аймгийн төсөвт нийт 2 тэрбум 525.6 сая төгрөг хүрч, төлөвлөгөөг 115.3 хувиар, үүнээс татварын орлого 1 тэрбум 772.1 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 112.0 хувиар биелүүлсэн байна. Татварын бус орлого 194.7 сая төгрөг төлөвлөгөөг 131.3 хувиар, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 556.9 сая төлөвлөгөөг 121.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Төсөв

Орон нутгийн зарлага санхүүжилтэнд эзлэх хувь




## Төсвийн зарлага

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилтын 76.6 хувийг зарцуулав. Үүнд цалин хөлс нэмэгдэл урамшууллын төлөвлөгөөний 92.2 хувь, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн 90.9 хувь, бараа үйлчилгээний бусад зардлын 71.4 хувийг тус тус санхүүжүүлсэн байна. Орон нутгийн төсвийн байгууллагууд 17.3 сая төгрөгийн авлагатай, 146.7 сая төгрөгийн өглөгтэй ажиллажээ.

# 2018 ОНЫ АЙМГИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

**Харилцаа холбооны үйлчилгээний орлого мян.төг**




**Суурин утасны цэгийн тоо**




Суурин телефон цэгийн тоо 561, холбооны газрын орлого 65.3 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 45.7 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

# *Анхаарал хандуулсанд баярлалаа.*

**Говь-Алтай аймаг, Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс**
**Утас : (7048-4278)**
**(7048-3442)**
**Э-майл : stat_altai@yahoo.com**